



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/38

Улаанбаатар хот

Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2016 онд
оюутан элсүүлэх журам шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11.3, 12.1.4, БСШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан Оюутан элсүүлэх журмын 1.2, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 19, 26-ны өдрүүдийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2016 онд оюутан элсүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Оюутан элсүүлэх ажлыг энэхүү журмын дагуу зохион байгуулах, үр дүнд нь хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба (Ч.Ундрэм), Мэдээллийн технологийн алба (А.Баатарбилэг), Бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/70 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2015 онд оюутан элсүүлэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

My document.Tushaal.2016.February

20160261

Захирлын 2016 оны 02 дугаар сарын 19-ны
өдрийн 138 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ
2016 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ*

1.1. Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2016 онд оюутан элсүүлэхэд Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журмыг баримтална.

1.2. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", элсэлтийн хяналтын тоонд багтан элсэх эрх авсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "элсэлтийн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн комисс" гэнэ.

1.3. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх оюутны хяналтын тоог Боловсрол соёл шинжлэх ухааны яам (БСШУЯ) тогтооно.

1.4. Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуульд элсүүлэхэд элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноог тооцох болон холбогдох бусад мэдээллийг <http://burtgel.num.edu.mn>, www.num.edu.mn цахим хуудсанд байршуулна.

1.5. МУИС-д гадаадын харьяат иргэдийг элсүүлэх асуудлыг "МУИС-д гадаадын иргэнийг элсүүлэн суралцуулах журам"-аар зохицуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

2.1. МУИС-ийн элсэлтийн төв комиссын дарга нь сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн дарга нь сургалтын нэгдсэн алба (СНА)-ны дарга, гишүүд нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, мэдээллийн технологийн албаны дарга, санхүү эдийн засгийн албаны дарга, салбар комиссын дарга нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн дарга нь сургалтын албаны эрхлэгч, гишүүд нь дэд захирлууд байна.

2.2. Комисс нь элсэлтийн ажлыг зохион байгуулах, үүнтэй холбоотой зохицуулалт хийх чиг үүргийг хариуцан гүйцэтгэнэ.

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

3.1. МУИС-д элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцаж элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлнэ.

*Бакалаврын зэрэгтэй иргэн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэх бол "МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам"-аар, өдрийн хөтөлбөрт элсэн суралцах хүсэлтэй бол энэхүү журмаар зохицуулагдана.

3.2. Бүртгүүлэгч нь БСШУЯ-ны Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-өөс зохион байгуулдаг ЭЕШ өгсөн хот, орон нутагтаа (харьяалал харгалзахгүй) өрсөлдөх эрхтэй.

3.3. Бүртгүүлэгч нь МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Бизнесийн сургууль, Хууль зүйн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Орхон сургууль, Завхан сургуулиас сонгож бүртгүүлнэ. Шинжлэх ухааны сургуулийн хувьд Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухааны салбараас сонгож бүртгүүлнэ. Бүртгүүлэгч нь өөрийн хүсэлтээр хэд хэдэн бүрэлдэхүүн сургуульд зэрэг бүртгүүлж болно.

3.4. Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн хүчинтэй батламжтай, эсвэл 2016 онд ЭЕШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байна.

3.5. Бүртгүүлэгч БҮТ-ийн систем дэх хувийн мэдээлэл, цахим шуудангийн хаяг, утасны дугаараа нягталж, алдаа мадаггүй болгосон байх шаардлагатай. Элсэлтийн системд бүртгүүлэгчийн оруулсан алдаатай мэдээллээс хамааран элсэлттэй холбоотой мэдээллийг авч чадаагүй бол МУИС хариуцахгүй.

3.6. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн МУИС-д элсэх хүсэлт гаргахдаа элсэхийг хүсч буй бүрэлдэхүүн сургуулийн элсэгчдийн онооны жагсаалтанд харгалзах "суурь" болон "дагалдах" ЭЕШ-тай дүйцүүлж болох шалгалтыг гадаад оронд өгсөн тухай тодорхойлолт, баримтыг хавсаргасан байна.

3.7. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн иргэдийн өргөдлийг цахимаар хүлээн авч салбар комиссын саналыг үндэслэн төв комисс шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

4.1. МУИС-д элсэхийг хүссэн иргэд орон даяар, цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар бүртгүүлнэ. Бүртгэлийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны 09:00 цагт нээж 6 дугаар сарын 30-ны 18:00 цагт хаана.

4.2. Бүртгүүлэгч МУИС-ийн элсэлтийн системд БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээрээ нэвтэрч зааврын дагуу холбогдох талбаруудад мэдээллээ оруулж элсэх хүсэлтээ гаргана.

4.3. Бүртгүүлэгч хувийн мэдээллээ шалгаж баталгаажуулсны дараа сонирхсон бүрэлдэхүүн сургууль/салбараа сонгон элсэлтийн бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна (цахим картаар төлбөр хийх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн бүртгэлийн системээс үзэх боломжтой).

4.4. Элсэлтийн бүртгэлийн хураамж 15000 төгрөг байна. Энэ хураамжийг төлсөн бүртгүүлэгчийн сонгох сургууль/салбарын тоонд хязгаар тогтоохгүй. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ

5.1. БСШУЯ-аас тогтоосон улсын болон олон улсын олимпиадад оролцсон, БСШУЯ-аас тавих ЭЕШ-ын босго оноог хангасан Ерөнхий боловсролын сургууль (ЕБС) төгсөгчийг тухайн чиглэлээр БСШУЯ-ны тодорхойлолт болон холбогдох баримт бичигт үндэслэн шууд элсүүлнэ. Бизнесийн сургууль, Хууль зүйн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн суурь шалгалтад заасан хичээлүүдээр улсын олимпиадад I-ҮІ байр эзэлсэн бүртгүүлэгчийг шууд элсүүлнэ.

Энэ нөхцөлийг хангасан бүртгүүлэгч “олимпиад” гэсэн ангиллаар бүртгүүлж, журмын 4.4-д заасан бүртгэлийн хураамж төлнө.

5.2. БҮТ-өөс ЭЕШ-ын дүнг албан ёсоор зарласан даруйд МУИС-ийн элсэлтийн систем бүртгүүлэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг татан авч, холбогдох тооцооллыг хийж, онооны жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулиар тодорхойлж харуулна.

5.3. Бүртгүүлэгчийн оноог дараах байдлаар тооцно. “Суурь” шалгалтанд тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.6 (Бизнесийн сургуульд бол 0.8)-аар, “Дагалдах” шалгалтад тооцохоор заасан хичээлээс мөн хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.4 (Бизнесийн сургуульд бол 0.2)-өөр үржүүлж нэмнэ. Ийнхүү тооцох “Суурь” болон “Дагалдах” шалгалтад оноо нь тус бүр БСШУЯ-наас баталсан Их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй байна. Суурь шалгалтад тооцуулсан хичээлийн оноог дагалдах шалгалтад тооцуулахгүй.

5.4. Өмнөх нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

5.5. Хяналтын тоонд багтсан эсэхийг бүртгэл хаасны дараа тогтоосон хугацаанд элсэлтийн системээр бүртгүүлэгчид мэдэгдэнэ.

ЗУРГАА. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

6.1. Элсэх эрх олгох үйл ажиллагааг орон даяар цахим хэлбэрээр явуулна.

6.2. Журмын 5.1 дүгээр заалтаар бүртгүүлэгч нь олимпиадад оролцсоныг гэрчлэх бичиг баримтын эх хувь, тэдгээрийн хуулбарын хамт 2016 оны 06 дугаар сарын 20-ноос 30-ны хооронд ажлын цагаар Сургалтын нэгдсэн албанд авчирна.

6.3. Элсэлтийн эрх олгох үйл ажиллагааг БҮТ-өөс ЭЕШ-ын оноог нийтэд зарласан өдрөөс эхлэн долоо хоногийн хугацаанд зохион байгуулна.

6.4. Хэд хэдэн сургууль/салбарын хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг сургууль/салбарыг сонгох ба энэ нөхцөлд бусад сургууль/салбарын хяналтын тооны жагсаалтаас нэр нь хасагдаж босго шугам нэгээр доошилно. Босго шугам доошилсны дүнд хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчид элсэх эрх үүсч байгааг элсэлтийн системээр мэдэгдэнэ.

6.5. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэлтийн системд нэвтэрч хичээлийн жилийн эхний улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахимаар төлж баталгаажуулна. Элсэн суралцахаа баталгаажуулснаа цуцлах тохиолдолд суурь үйлчилгээний төлбөрийг буцаан олгохгүй.*

6.6. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсоноос хойш 24 цагийн дотор элсэн суралцахаа баталгаажуулна. Хэрэв ингэж баталгаажуулаагүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзэн жагсаалтын дараах бүртгүүлэгчийг босго шугамын дээр дэвшүүлэн элсэх эрх шилжинэ.

*Хуваарь буцааснаар тухайн хуваарийг авах боломжтой, жагсаалтын дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрч, эрх ашиг нь хөндөгддөг тул хариуцлагатай сонголт хийх ёстой гэдэг үүднээс урьдчилж төлүүлдэг. Түүнчлэн МУИС нөхөн элсэлт зохион байгуулахад хүрвэл гарах зардлыг энэхүү суурь үйлчилгээний төлбөрөөс санхүүжүүлдэг болно.

6.7. Элсэгч нь суралцахаа баталгаажуулсны дараа түүний цахим шуудангийн (e-mail) хаягаар МУИС-д суралцах журамтай холбогдох мэдээлэл, мэдээллийн системийг ашиглах заавар зэргийг илгээнэ.

ДОЛОО. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

7.1. Элсэгчид нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн ~~2016-оны-08-дугаар-сарын~~ 01-нээс 08 дугаар сарын 22-ны хооронд ажлын цагаар бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд өөрийн биеэр авчирч бүртгүүлнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрт) хамт;
- МУИС-д элсэгчийн анкет(МУИС-ийн загварын дагуу);
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг, хуулбарын хамт);
- ЭЕШ-ын батламж, хуулбарын хамт;
- Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхийн шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан) бүрдүүлэн эдгээр бичиг баримтыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

НАЙМ. БУСАД

8.1. Нэг бүрэлдэхүүн сургуулиас нөгөө бүрэлдэхүүн сургууль/салбарт шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрөхгүй.

8.2. Элсэх эрхээ баталгаажуулсан боловч, бүрдүүлэх бичиг баримтаа 7.1-д заасан хугацаанд авчирч бүртгүүлээгүй бол МУИС-д суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.

8.3. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол МУИС-д элсүүлэхгүй.

8.4. Цахим бүртгэл хийж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, утас, мессенжер, цахим шуудан, вэб хуудас зэргийг ашиглан явуулна.

МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2016 онд оюутан элсүүлэх журмын хүснэгт

	МУИС-ийн БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ	ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ		СОНГОХ БОЛОМЖТОЙ БАКАЛАВРЫН ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР
		“Суурь” шалгалт (60%)	“Дагалдах” шалгалт (40%)	
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Багш, байгалийн ухааны боловсрол • Багш, математикийн боловсрол • Байгаль орчныг зайнаас тандан судлал • Биологи • Биологийн нөөц судлал • Биохими • Биотехнологи • Газарзүй • Газар зохион байгуулалт • Геологи • Геофизик • Математик • Физик • Хими • Хот ба бүс нутгийн төлөвлөлт • Экологи
2	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> • Математик • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Монголын түүх • Орос хэл • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Антропологи • Археологи • Нийгмийн ажил • Социологи • Сэтгүүлзүй • Сэтгэл судлал • Улс төр судлал • Эдийн засаг
3	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Багш, гадаад хэлний боловсрол • Багш, монгол хэл- уран зохиолын боловсрол • Багш, нийгмийн ухааны боловсрол • Гадаад хэлний орчуулга • Олон улс, орон судлал • Түүх • Урлаг судлал • Утга зохиол судлал • Философи • Хэл, уран зохиол /Монгол хэл, уран зохиол, Гадаад хэл, уран зохиол/

				<ul style="list-style-type: none"> • Хэлшинжлэл /Монгол хэл шинжлэл, Гадаад хэл шинжлэл/ • Шашин судлал
4	ХЭРЭГЛЭЭ НИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧ ЛЭЛИЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Биологи • Математик • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах технологи • Био-инженерчлэл • Компьютерийн сүлжээ • Компьютерийн ухаан • Материал судлал • Мэдээллийн систем • Мэдээллийн технологи • Нано шинжлэх ухаан, инженерчлэл • Ойн үйлдвэрлэлийн техник, технологи • Программ хангамж • Статистик • Сэргээгдэх эрчим хүч • Ус судлал • Химийн инженерчлэл • Холбооны технологи • Хүрээлэн буй орчин судлал • Хэрэглээний математик • Хэрэглээний хими • Цаг уур • Цөмийн инженерчлэл • Электрон системийн автоматжуулалт
5	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Математик^{80%} 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл^{20%} • Нийгмийн тухай мэдлэг^{20%} • Орос хэл^{20%} 	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын менежемент • Бизнесийн удирдлага • Даатгал • Зочлох үйлчилгээ • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү, банк
6	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Математик 	<ul style="list-style-type: none"> • Эрхзүй
7	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Математик • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Математик • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Нийтийн удирдлага • Олон улсын харилцаа

8	ОРХОН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл • Англи хэл • Орос хэл • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Багш, гадаад хэлний боловсрол • Гадаад хэлний орчуулга
		<ul style="list-style-type: none"> • Монгол хэл 		<ul style="list-style-type: none"> • Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол
		<ul style="list-style-type: none"> • Математик 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Даатгал • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү, банк
9	ЗАВХАН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Математик 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Нягтлан бодох бүртгэл • Санхүү, банк • Маркетинг • Менежмент • Худалдаа • Бичиг хэрэг, оффисийн ажилтан
		<ul style="list-style-type: none"> • Математик • Физик 	<ul style="list-style-type: none"> • Биологи • Математик • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Электрон системийн автоматжуулалт
		<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Математик • Монгол хэл • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Багш, гадаад хэлний боловсрол (англи)

Тайлбар:

1. МУИС-д элсэхийг хүссэн иргэн хүснэгтэд заасан бүрэлдэхүүн сургууль/салбарт бүртгүүлэх бөгөөд ЭЕШ-ын шалгалтын оноогоороо элсэлтийн хяналтын тоонд багтсан тохиолдолд МУИС-ийн оюутан болж элсэх эрхтэй болно. Элсэгч нь тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын бүх хөтөлбөрөөс мэргэжлийн хөтөлбөр сонгуулах журамд зааснаар сонгон суралцах бололцоотой бөгөөд сурлагын дүн, анх элсэхээр бүртгүүлэхдээ тооцуулсан ЭЕШ-ын оноо өндөр байх тусам мэргэжил сонгохдоо давуу эрх эдэлнэ. ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын бүх хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой. Түүнчлэн зарим хөтөлбөрийн хувьд бэлтгэж буй мэргэжил, шинжлэх ухааны онцлогоос үүдэн оюутанд тусгай шаардлага тавина.

2. МУИС-д элссэн оюутан нь өөрийн сонгосон үндсэн мэргэжлээс гадна МУИС-ийн санал болгох "Хавсарга" мэргэжлээс сонгон судалж, "Үндсэн мэргэжил", "Хавсарга мэргэжил" эзэмших боломжтой болно. Жишээлбэл, ШУС-д Физик мэргэжлээр суралцаж байгаа оюутан Бизнесийн сургуулийн Менежмент хөтөлбөрөөр хавсарга мэргэжил эзэмших боломжтой.

3. ШУС болон ХШУИС-д элсэн орсон элсэгчид гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөрт (honours program) хамрагдах боломжтой ба тусгай журмаар зохицуулна. Энэхүү хөтөлбөр нь зөвхөн суурь боловсрол олгох бөгөөд бусад оюутны адил мэргэжлээ сонгон суралцана.

*** *** ***